

Монголын анагаах ухаанд зүрхний мэс заслыг үндэслэгч нь Академич Түндэвийн Шагдарсүрэн мөн

Соёлмаа Ч.¹, Тулгаа Л.², Баасанжав Н.²

¹“Ач” Анагаах ухааны их сургууль, ²Анагаах ухааны хүрээлэн

Abstract

Academician Tundev Shagdarsuren is the founder of cardiac surgery in Mongolia

Soyolmaa Ch.¹, Tulгаа L.², Baasanjav N.²

¹“Ach” Medical university, ²Institute of medical sciences

Background

In recent years, Mongolian cardiac surgery, which included many people who have contributed to the history of development? One of them is an academician T.Shagdarsuren, whose historic feat is exceptional. He spent the great times of scientific, hospital, surgical field. The coursework is continuing to learn and study from the experienced person. It is an essential example for our younger generations.

Objective

To study the history of cardiac surgery of the world and an academician Tundev Shagdarsuren's contributions to the development of the Mongolian cardiac surgery

Materials and Methods

Major methodological principles have been made by anthropology and history, text sources, analytical methods, that to analyze T.Shagdarsuren's biographies and works related to the archives, to find some materials scientists at the Institute of Medicine, researchers and memories of his disciples' talk and texts. As well as research work and time were done in to the correct order due to enrich other works of the additional information in according to rules of conducting medical research discipline.

Results

T.Shagdarsuren established thoracic surgical department of the first surgical hospital in Mongolia in 1954. Furthermore, he did the first thoracic surgery and cardiac surgery in this department. Cardiac surgical treatment is resolved some of the priority issues. As a result, with the advent of thoracic surgery of medical care for sick people closer, improved surgery techniques. Therefore, Cardiovascular research for improving the quality of medical diagnosis, which is achieved a new approach to medical practice by introducing.

Conclusion: Academician T.Shagdarsuren is a famous doctor and good organizer, who initially established a team for providing cardiovascular medical services including a number of surgeries. He introduced new technologies which contributed to the development of chest cavity and cardiovascular diagnosis and surgeries and allowed us to be on the same path of other countries around the world.

Pp. 49-53, References 8

Оршил

Аливаа үндэстэн өнгөрсөн түүхээ эргэн санах, мэдэх, өнөөдрийн бодит байдлаа эргэцүүлэн дүгнэхгүйгээр ирээдүйгээ төсөөлөх боломжгүй байдаг. Цаг хугацааны түүх нь өнгөрсөн, одоо, ирээдүйн залгамж холбоо болж өгдөгөөрөө ач холбогдолтой. Манай орны анагаах ухааны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан эрдэмтэн

судлаачдын түүх, замналыг шинжлэх ухаан болон өв уламжлалын үүднээс хойч үедээ дэлгэн үзүүлэх, үлгэр дууриалал болгох хэрэгцээ, шаардлага орчин үеийн анагаах ухааны судалгаанд гарч байна. Манай оронд зүрхний мэс засал бол өнгөрсөн зууны хоёрдугаар хагаст үүсч хөгжиж эхэлсэн, одоо ч эрчимтэй хөгжиж байгаа анагаах ухааны тэргүүлэх салбарын нэг юм.

Зорилго

Зүрхний мэс засал үүссэн түүх болон Академич Т.Шагдарсүрэнгийн манай оронд зүрх судасны мэс засал үүсэхэд оруулсан хувь нэмрийг судлах

Материал, арга зүй

Судалгаанд:

1. Ном, сонин, сэтгүүл, судалгааны материал
2. Анагаах ухааны хүрээлэнгийн түүхэн эх сурвалжууд
3. Т.Шагдарсүрэнгийн намтар, бүтээлтэй холбоотой архивын материалууд
4. Анагаах ухааны хүрээлэнгийн эрдэмтэд, судлаачид, .
5. Т.Шагдарсүрэнгийн шавь нарын дурсамж яриа, бичвэрүүдийг судалгааны ажилд түүвэрлэн авч цаг хугацааны дараалалд оруулан өөр бусад бүтээлүүдийн мэдээллээр баяжуулан оюуны дүгнэлт хийсэн.

Судалгааны дараах аргуудыг ашиглалаа:

- Түүхэн хүн судлах
- Эх бичиг архивын материал судлах
- Баримт бичгүүдийг боловсруулах арга
- Эх сурвалжид дүн шинжилгээ хийх

Үр дүн

Анагаах ухааны эцэг болох Грекийн эмч Гиппократ, эртний Ромийн алдарт эмч байгаль судлагч Гален, эмч гүн ухаантан Авиценна нар бүгд зүрхний шархыг зайлшгүй үхэлд хүргэдэг гэж үзэж байв. 1568 онд Париж хотноо хоёр хүн дуэль хийхдээ Францын мэс засалч Амбруаза Парег гэрч шүүгчээр урьжээ. Халз тулалдсан хоёр хүний нэг нь нөгөөгийнхөө цээж рүү сэлмээрээ хатгахад хатгуулсан хүн улам их довтолж, нөгөөх нь зугтсан байна. Ингээд шархадсан хүн 200 алхам газар гүйгээд унажээ. Эмчийг очиход тэр хүн нас барсан байв. Шархыг үзтэл зүрхээ сэлмээр нэвт хатгуулсан байжээ. Зүрхэндээ шарх авсан хүн тэр дороо үхнэ гэж хэдэн зуун жилийн турш тооцож байлаа. Гэтэл энэ хүн 200 алхам газар гүйж байгаад нас барсан нь тэр үед маш сонин тохиолдол байлаа. Мөн 1641 онд зүрхэндээ хатгуулсан нэг хүн 15 хоног амьд байж байгаад 16 дахь хоног дээрээ нас баржээ. Зүрхээ сэлмээр нэвт хатгуулчаад 200 алхам газар гүйсэн, зүрхэндээ хатгуулаад 15 хоногийн турш амьд байсан явдлууд нь тэр үед үнэхээр сонин тохиолдлууд байжээ. Зүрхний шархыг оёдоггүй байсан тэр үед ийм өвчтэй хүнийг гол төлөв тайван хэвтүүлж хүйтэн жин тавих, заримдаа

цуснаас нь авдаг байв. Энэ аргаар эмчлэхэд 10-12% эдгэрч бусад нь нас бардаг байжээ. Дэлхийд нэрд гарсан гарамгай мэс засалч Австрийн эмч Бильрот 1883 онд бичихдээ зүрхний шархыг оёх гэсэн мэс засалч мэргэжил нэгт нөхдийнхөө дотор ямар ч нэр хүндгүй болно гэж байсан нь зүрхний шархыг оёж болохгүй гэсэн ойлголт хичнээн хүчтэй байсныг харуулах нэг баримт юм.

Гэвч анагаах ухаан хөгжиж мэс засал хийхэд мэдээ алдуулж өвчингүй болгох арга, шарх ба мэс заслын багаж хэрэгсэл, материалуудыг ариутган цэвэрлэж үжилгүй болгох аргууд өргөнөөр хэрэглэгдэж зүрх судаснуудын зохион байгуулалт, үйл ажиллагааг өргөн судлаж, олон нээлтүүд хийсэн нь зүрхэнд мэс засал хийх нөхцлийг 19 дүгээр зууны эцсээр бүрдүүлжээ.

1895 онд Норвегийн мэс засалч Каппелан анх зүрхний шархыг оёсон бөгөөд тэр өвчтөн нь 2 хоноод нас баржээ [1]. Дэлхийд анх удаа 1896 оны 9 сарын 9-ны өдөр Франкфурт хотод Германы мэс засалч Л.Рен баруун ховдлын шархыг оёж өвчтөнг эдгээсэн нь зүрхний мэс заслын түүхэнд эргэлтийн үе болжээ. Үүнээс хойш дэлхийн хэд хэдэн оронд зүрхний шархыг оёх мэс засал нилээд хийх болсон ч нас баралт өндөр байлаа.

20 дугаар зууны сүүлчээс дэлхийн алдарт мэс засалч Бильрот, Калтер, Бейли, И.И.Насилов, В.Д.Добромыслов, А.А.Вишневский, Ю.Ю.Джанелидзе, А.Н.Бакулев, П.А.Купринянов, П.В.Петровский зэрэг эрдэмтдээс цээжний хөндий болон зүрх судасны мэс заслын талаар гаргасан суут бүтээлүүд нь тэр үеийн бахархал болсон байна [1, 2]. Мөн Оросын нэрт мэс засалч Ю.Ю.Джанелидзе зүрхний шархыг анх удаа оёж эдгэрүүлсэн байна [2].

Анагаах ухаан хөгжих тутам мэс заслын арга барил улам сайжирч үр дүн нь жилээс жилд сайжирсаар байв. Зүрхний шархыг оёх, мэс заслын дараах эдгэрэлт 1953 онд 70%, 1957 онд 83,2% болж өссөн нь зүрхний мэс засалд анхны том алхам болсон [1]. Зүрхний үнхэлцэг хальсны мэс заслыг Немцийн мэс засалч Л.Рен 1913 онд, Орос улсад мэс засалч А.Н.Бакулев 1932 онд анх удаа хийж өвчтөний амь насыг аварч байжээ.

Хуягласан зүрхэнд мэс засал хийх болсон нь зүрхний мэс заслын 2 дахь том алхам болжээ. Үүний дараагаар зүрхний гажигуудыг мэс заслаар эмчлэх шаардлагатай байлаа.

Зүрхний төрөлхийн гажиг амьд төрсөн нийт хүүхдийн дунд нэмэгдэж байгааг олон орны эрдэмтэд судалж тогтоосон байна. Америкийн нэгдсэн улсын нэрт эрдэмтэн, зүрх судасны мэс

засалч Лиллехейний 1959 оны судалгаагаар дэлхий дээр хоногт зүрхний төрөлхийн гажигтай 2000 хүүхэд, жилд ийм гажигтай 50000 хүүхэд төрдөг байжээ [1]. Орос улсын Анагаах Ухааны Академийн зүрх-судасны мэс заслын хүрээлэнгийн эрдэмтдийн судалгаагаар 1983 онд 5,5 сая хүүхэд төрсний 44000 хүүхэд зүрхний гажигтай байжээ. Английн эрдэмтэн Файлерийн 1980 оны судалгаагаар зүрхний гажигтай төрсөн хүүхдүүдийн 40% ойндоо хүрэлгүй энддэг болохыг тогтоосон байна [1]. Иймээс зүрхний төрөлхийн болон олдмол гажгийг мэс заслаар эмчлэх шаардлага гарч эхэлсэн юм. Зүрхний гажгийг мэс заслаар эмчлэх анхны хагалгааг 1938 онд Америкын мэс засалч Р.Гросс амжилттай хийжээ [1, 6, 7].

Энэ мэтчилэн зүрхний олон төрлийн эмгэг, гажгийг мэс заслаар эмчлэх эрин үе эхлэхэд мэдээгүйжүүлэх, эм судлал, лаборатори гэх мэтчилэн анагаах ухааны олон салбарт хийгдсэн ололт амжилт нээлтүүдээс гадна олон төрлийн багаж хэрэгсэл, аппарат, тоног төхөөрөмж, шинэ арга барилыг судлан боловсруулж практикт нэвтрүүлэх шаардлага тавигдсан байна. Бие махбодид хүчилтөрөгчийн нөөцийг бий болгож зүрхэнд хагалгаа хийх аргыг Голландын эрдэмтэн мэс засалч Борема үндэсэлсэн бөгөөд анхны хагалгааг 1960 онд хийжээ. Үүнээс хойш Америк, Япон, Орос улсад энэ аргыг өргөн хэрэглэж эхэлсэн байна [4].

Биеийн халууныг бууруулж нээлттэй зүрхэнд хагалгаа хийх аргыг анх мэс засалч Д.Люис 1952 онд 5 настай охинд зүрхний таславчийн цоорхойг оёж хийсэн нь амжилттай болжээ. ЗХУ-д энэ аргыг 1958 онд А.А.Вишнеvский хийсэн байна [4].

Цусны зохиомол эргэлтийн аппаратыг Оросын эрдэмтэн С.С.Брюхоненко анх 1924 онд бүтээсэн бөгөөд, анхны хагалгааг Америкийн мэс засалч Д.Гиббон 1953 онд 17 настай охинд зүрхний тосгуурын таславчийн цоорхой гажгийг битүүлэх хагалгааг хийжээ. Орос улсад алдарт мэс засалч, Академич А.А.Вишнеvский 1957 онд хийсэн байна [4]. Цусны зохиомол эргэлтийн арга нэвтэрснээр урьд өмнө эмчилж чаддаггүй байсан зүрх судасны олон төрлийн гажиг өвчнүүдийг мэс заслаар эмчилж олон мянган хүнийг эрүүл саруул болгож чаддаг болов.

Зүрх судасны мэс заслын дараагийн ололт нь зүрхний гэмтсэн хавхалгыг авч хиймэл хавхалгаар солих хагалгааг Анх эрдэмтэн Альберт Старр анх бүтээж 1960 онд өвчтөний хоёр хавтаст хавхалгийн оронд суулгасан байна [1].

20-р зууны анагаах ухааны мэс заслын оргил амжилт болсон хүний зүрхийг шилжүүлэн суулгах гайхамшигт мэс засал цусны зохиомол эргэлтийн аргатай салшгүй холбоотой юм. Анх энэ мэс заслыг Өмнөд Африкийн Бүгд Найрамдах улсын Кейптун хотын мэс засалч Кристиан Бернард 1967 оны 12 сард хийсэн боловч өвчтөн 19 хоноод нас барсан. 1 сарын дараа хоёр дахь хагалгааг хийж, уг өвчтөн 2 жил гаруй насалсан билээ. Үүнээс хойш Америкийн нэгдсэн улс, Канад, Франц, Герман зэрэг орнуудад энэ хагалгааг нэлээд хийж эхэлсэн. Орос улсад зүрх шилжүүлэн суулгах анхны хагалгааг профессор В.И.Шумаков 1987 онд хийжээ. Энэ мэтчилэн 20 дугаар зууны хоёрдугаар хагаст зүрх судасны мэс засал асар хурдтай хөгжиж эхэлсэн.

Манай оронд 1954 онд мэс заслын эмнэлэг анх байгуулагдахад Т.Шагдарсүрэнгийн санаачилгаар 25 ортой цээжний хөндийн мэс заслын тасаг байгуулагдаж Д.Доржготов, П.Е.Бадер нартай хамт ажиллаж, зүрх судасны мэс заслын суурийг тавьжээ [5, 6]. Академич Т.Шагдарсүрэн цээжний хөндийн эрхтэнүүдийн хортой ба хоргүй хавдар, идээт өвчнүүд, гэмтэл зэрэгт анхны хагалгаануудыг хийж эхэлжээ. 1952 онд амьсгалын замыг дурандах аргыг нэвтрүүлж, 1958 онд улаан хоолойн хорт хавдартай өвчтөнд Ру-Герцийн аргаар нарийн гэдсээр орлуулах хагалгаа, 1960 онд уушигны бэтэгний улмаас дэлбэн тайрах хагалгааг тус тус анх удаа хийсэн байна.

Т.Шагдарсүрэн дээрхи хугацаанд зүрх судасны зарим хагалгааг анх удаа хийжээ.

- 1957 онд зүрхнээс зүү авах
- 1958 оны 10 сард артерийн битүүрээгүй цорго боох хагалгаа
- 1960 оны 2 сард зүрхний хоёр хавтаст хавхалгийн нарийслыг тэлэх хагалгаа
- 1960 оны 1 сард зүрхний бэтэг авах
- 1963 оны 2 сард үнхэлцэг хальсны наалдаст үрэвслийн улмаас үнхэлцгийг хэсэгчлэн хуулж авах хагалгааг тус тус амжилттай хийсэн байна.

1967 онд зүрх судасны мэс заслын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх зорилгоор 9 хүнтэй багийг Академич Т.Шагдарсүрэн өөрөө удирдан Москва хотын А.Н.Бакулевын нэрэмжит зүрх судасны мэс заслын төв хүрээлэнд 4 сарын дамжаанд суралцуулсан байна.

Академич Т.Шагдарсүрэнгийн санаачилга оролцоотойгоор 1969 оны 4 дүгээр сарын 12-

нд Б.Н.Шастины нэрэмжит клиникийн нэгдсэн 3 дугаар эмнэлэгт Элема-Сименсийн зүрх-судсыг сэтгүүрдэх, нэг секундэд 6-12 зураг, мөн кино зураг авах чадалтай рентген ангиографийн “Элема” төхөөрөмж, хагалгааны дараа өвчтөний зүрхний цахилгаан бичлэг, цусны даралт, амьсгал, судасны тоо, биеийн халуун зэргийг нэг бүрчлэн хянадаг дуу болон гэрлэн дохиолол бүхий 6 орны хяналтын систем, цусны эргэлтийн (Швед улсын АГА фирмийн) аппарат, цусанд эрдэс болон хийн найрлагыг тодорхойлдог микроаструп аппарат, зүрхний цахилгаан бичлэгийн болон наркоз, хиймэл амьсгалын энгестрем аппарат суурилуулан тавьж зүрх судасны мэс заслын тасгийг 50 ортойгоор нээсэн байна [1, 6].

1964 онд Зүрхний мэс заслын хагалгааны арга техникийг эзэмших, онцлогийг судлах зорилгоор туршлагын лаборатори байгуулж нохой дээр зүрхний таславчийн цоорхойг оёх мэс засал 18, судас залгах хагалгаа 32, том судас тайрч хиймэл судсаар орлуулах хагалгааг 9 удаа хийсэн байна [6, 8, 9].

Зүрхний мэс заслын үйл ажиллагааны эхний жилүүдэд зүрхний хавхлагийн нарийслыг засах, гадны биет авах зэрэг зүрхний хаалттай хагалгаануудыг хийж эхэлсэн.

1969 оны 10 дугаар сард биеийн халууныг бууруулсан нөхцөлд нээлттэй зүрхний анхны хагалгааг, 1970 оны 5 дугаар сард цусны зохиомол эргэлттэй хагалгааг тус тус хийсэн байна.

Зүрхний төрөлхийн ба олдмол олон төрлийн гажигуудыг засах хагалгаанууд хаалттай, нээлттэй зүрхэн дээр манай орны эмнэлгийн нөхцөлд анх удаа хийгдсэн бөгөөд тэр бүгдийн анхдагч нь Академич Т.Шагдарсүрэн байсан.

Зүрхний мэс заслын салбарыг үүсгэн хөгжүүлэхэд Т.Шагдарсүрэнгийн дотны туслагч, гарын шавь нь АУ-ны доктор, Төрийн шагналт мэс засалч Сандагийн Загд юм. Тэрээр зүрх сэтгүүрдэх, ангиокардиографийн мэргэжлээр суралцаж, зүрх-сэтгүүрдэх аргаар шинжлэн онош тогтоох аргуудыг гардан хийж анх нэвтрүүлсэн. Мөн Т.Шагдарсүрэн багшийн нэгдүгээр туслахаар ихэнх хагалгаанд оролцож байв.

Академич Т.Шагдарсүрэн 1967 онд Анагаах Ухааны Дээд сургууль төгсөгчдөөс 4 залуу эмчийг Анагаах Ухааны Хүрээлэнд авч ажиллуулсан бөгөөд түүний нэг нь зүрхний мэс заслын хоёр дахь зөвлөх шавь Анагаах Ухааны доктор Цамбын Бундан юм.

Академич Т.Шагдарсүрэнгийн сургаж бэлтгэсэн зүрхний мэс заслын гурав дахь зөвлөх шавь нь

Академич Начингийн Баасанжав юм. Тэрээр 1989 оноос эхлэн зүрх-судасны багийг тэргүүлэн үйл ажиллагааг удирдан зохион байгуулан ажиллаж байгаа.

Зүрхний мэс заслын нэг чухал алба бол мэдээгүйжүүлэх, сэхээн амьдруулахын салбар юм. Манай оронд Академич Т.Шагдарсүрэнгийн санаачилгаар түүний удирдаж байсан мэс заслын тэнхим дээр 1960 онд мэдээгүйжүүлэх-сэхээн амьдруулахын мэргэжилтэн бэлтгэх анхны курсыг зохион байгуулж 8 эмч суралцаж төгссөний нэг нь Анагаах ухааны доктор, профессор Ж.Моондой юм. 1967 онд зүрх-судасны мэс заслын мэргэжлийн багийн бүрэлдхүүнд орж А.Н.Бакулевиин нэрэмжит зүрх судасны мэс заслын хүрээлэнд суралцсан. Нээлттэй зүрхний хагалгаа болох өвчтөний биеийг хөргөх, сэргээх аргыг мэдээгүйжүүлэгч эмч гардан хариуцаж хийдэг. Ж.Моондой энэ мэргэжлийг гарамгай эзэмшсэн асар их туршлагатай эмч эрдэмтэн байсан. Ж.Моондойгийн дараагийн залгамж нь түүний шавь Шинжлэх ухааны доктор, профессор О.Сүхбаатар юм.

1967 оны намар Москва хотын А.Н.Бакулевиин нэрэмжит зүрх судасны мэс заслын хүрээлэнд зүрх судасны мэс заслын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх сургалтанд Ёндонгийн Бодьхүү багтаж цусны зохиомол эргэлт буюу перфузолог мэргэжлээр суралцсан.

Зүрх-судасны мэс заслын бас нэг чухал салбар бол лабораторийн салбар байдаг. Манай оронд урьд өмнө хийгдэж байгаагүй шинжилгээний олон арван аргуудыг анхлан нэвтрүүлж, үүсгэн байгуулан олон жил удирдаж ажилласан хүн бол Анагаах Ухааны доктор С.Ямаахай юм. Өвчний оношлогооноос гадна эрхтэн, системийн үйл ажиллагааны байдал гарсан өөрчлөлтүүдийг тогтоож, хагалгаанд сонгох, бэлтгэх, хагалгааны явцад цусны хийн найрлага, хүчил-шүтийн тэнцвэр, уураг, эрдэс бодисуудын хэмжээ зэргийг тогтмол шалгаж, засч залруулах, хагалгааны дараа хийгдэж буй эмчилгээний үр дүнг хянах, засахад лабораторийн шинжилгээ чухал ач холбогдолтой байдаг.

Зүрхний мэс заслын дараагийн чухал сабар бол оношлогооны рентген-ангиографийн шинжилгээний салбар юм. Зүрхний төрөл бүрийн өвчин, гажгийг оношлох аргыг төгс эзэмшсэн, асар их туршлагатай хүн бол Монгол Улсын Ардын эмч Рэнцэнгийн Пүрэв байв.

Зүрхний мэс заслын өвчнүүдийг илрүүлж анхны онош тавих, цаашид хийх нарийвчилсан шинжилгээг сонгох, зүрх сэтгүүрдэх ангиографийн

шинжилгээнд заавал оролцож, зүрхний цахилгаан бичлэг, зүрхний тасалгаанууд, том судасны даралт хэмжих, хагалгааны үед кардиоплегийн аргаар зүрхний агшилт зогсоосны дараа агшилтыг сэргээж хэвийн болгоход зүрхний эмчийн оролцоо маш хэрэгтэй байдаг. Энэ хариуцлагатай үүргийг Анагаах ухааны доктор Д.Эрдэнэчулуун эмч гүйцэтгэж байсан.

Зүрхний мэс заслын оношлогоо, эмчилгээнд нарийн үйл ажиллагаатай, өндөр хүчин чадал бүхий аппарат тоног төхөөрөмж ашигладаг. Тэдгээрийг ажиллуулж, гэмтлийг нь засч сэлбэж байсан хүн бол алтан гарт инженер гэж хүндлэгдэн нэрлэгдсэн Дагдангийн Палам юм. 1968 онд Зүрх сэтгүүрдэх, ангиоргафийн анхны “Элема” төхөөрөмжийг Шведийн гурван мэргэжилтэн ирж суурилуулсан. Энэ төрлийн төхөөрөмж нь зүрх сэтгүүрдэх, үйл ажиллагааг харж хянадаг телевизийн дэлгэцтэй, судсанд тодруулах бодис шахдаг автомат шахуургатай, эгц болон хажуу талаас нэг секундэд 6-12 зураг авах чадалтай, мөн кино зураг авах төхөөрөмжтэй ихэнх үйлдэл нь автоматчилагдсан төхөөрөмж байв.

1969 оны 10 дугаар сард Ж.Моондой биеийг хөргөх аргыг хэрэглэн Монголд анх удаа нээлттэй зүрхний хагалгааг амжилттай хийсэн. 1970 оны 5 дугаар сард Ё.Бодьхүү цусны зохиомол эргэлтийн аргыг хэрэглэн хоёр дахь удаагаа нээлттэй зүрхний хагалгааг амжилттай хийж дэлхийн чихийг дэлдийлгэсэн. Зүрхний мэс заслын чиглэлээр Академичийн удирдсан багийн хийж байгаа ажлын тоо, хэмжээ, хүрээ, үр дүн жилээс жилд сайжирч оношлогоо эмчилгээний арвин туршлага хуримтлуулсаар байв. Академич Т.Шагдарсүрэн судалгаа шинжилгээний ажлыг, орчин үеийн техник, технологи, арга зүйд тулгуурлан өргөн хүрээтэй явуулж, зүрх судасны мэс заслын өвчнүүдийн тархалт, шалтгаан эмнэлзүйн онцлогийг тогтоож, эмчилгээний аргыг боловсронгуй болгох чиглэлээр санал гаргаж хэрэгжүүлсэн олон арван бүтээлийг тууриулав. 1972 онд Т.Шагдарсүрэн зүрхний болон цээжний хөндийн эрхтнүүдийн мэс заслын талаар тууриулан бүтээлүүдээрээ Анагаахын Шинжлэх Ухааны докторын зэрэг хамгаалсан.

Манай оронд 20-р зууны сүүлийн хагаст хөгжиж эхэлсэн зүрхний мэс засал нь дээр дурдсан

эмч эрдэмтэд болон нэр дурдагдаагүй олон олон эмч мэргэжилтнүүдийн санаачлага, нөр их хөдөлмөрийн ачаар орчин үеийн анагаах ухаанд тэргүүлэх ач холбогдолтой салбарын нэг болж чаджээ.

Дүгнэлт: Академич Т.Шагдарсүрэн нь манай оронд зүрх судасны тусламжийг анхлан хөгжүүлж, баг байгуулан ажиллаж, зүрх судасны олон хагалгаа хийж, энэ нарийн ажлыг дэлхийн түвшинд хүргэсэн, шинжлэх ухааны орчин үеийн ололтыг нэвтрүүлж, цээжний хөндий болон зүрх судасны мэс заслын онош эмчилгээний асуудлыг боловсронгуй болгоход үнэтэй хувь нэмэр оруулсан нэрт эрдэмтэн, алдартай эмч, шилдэг зохион байгуулагч байжээ.

Ном зүй:

1. Бодьхүү Ё. "Зүрхний мэс засал" 2003, х.5-9
2. Шагдарсүрэн Т. "Манай оронд цээжний мэс засал хөгжиж байгаа нь" ШУА-ын мэдээ 1961, №3
3. Мухар Ц. "Эрдмийн их чуулган - 50 жил" 2011, х.111
4. Галсумъяа Л. "Цусны зохиомол эргэлтийн үндэс" 2016, х.13-15
5. Дагданбазар Б. "Монголын анагаахын мэргэд" 18-р боть, 2013
6. Баасанжав Н., Жамбалдорж Я. "Монголын мэс заслын нэгэн зуун" х.18-19, 132-136, 142-143, 487-490.
7. Бодьхүү Ё. "Зүрх-судасны мэс заслын тусламжийн байдал, хэтийн төлөв" Монголын анагаах ухаан сэтгүүл 1981. №2
8. Монгол Улсын Төв архив. Х.Н-347, Д.Н-3, Х.Н-1
9. Батмөнх Ч. "Буурал эрдэмтний наян нас, буянт үйлсийн дөчин жил", 1998, 21х.

*Танилцаж, нийтлэх санал өгсөн:
Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор
Ц.Мухар*